

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/08/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа  
Утас: 93032714

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	9
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө .....	10
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт .....	10
3.5.3 Авлага .....	10
3.5.4 Урьдчилгаа .....	11
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	11
3.5.6 БАРАА МАТЕРИАЛ .....	11
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	11
3.5.8 Өр төлбөр.....	11
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	12
3.5.10 Орлогын данс.....	12
3.5.11 Зардлын данс.....	13
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	13
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	15
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	16
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	16
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	16
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.04.06 № 364

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

023030894

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,422,316.8	1,848,528.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	703,126.4	974,578.1
33	АВЛАГА	344,178.7	440,975.1
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	369,387.7	394,253.4
36	НӨӨЦИЙН БАРАА	5,624.0	11,020.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,960,675.9	13,926,727.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,960,675.9	13,926,727.0
392	Биет хөрөнгө	13,820,476.6	13,786,874.2
393	Биет бус хөрөнгө	140,199.4	139,852.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,382,992.7	15,775,255.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	61,827.9	5,307.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	61,827.9	5,307.4
413	Өглөг	61,827.9	5,307.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,321,164.8	15,769,948.1
51	Засгийн газрын хувь оролцоо	15,321,164.8	15,769,948.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,105,890.3	3,101,033.7
512	Хуримтлагдсан үр дүн	11,277,013.8	11,731,020.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	938,260.6	937,893.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,382,992.7	15,775,255.5

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13,220,403.7	7,363,790.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	711,411.5	750,574.0
110	Орлогын албан татвар	119,060.9	94,333.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	119,060.9	94,333.5
113	Хөрөнгийн албан татвар	4,960.0	148,565.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	587,390.6	507,674.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,094,140.4	628,683.2
120	Нийтлэг татварын бус орлого	9,094,140.4	628,683.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,414,851.8	5,984,533.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,824,156.0	6,603,310.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,824,156.0	6,603,310.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,639,048.0	4,406,931.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,090,479.0	2,199,265.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	263,159.0	291,537.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	488,968.3	521,806.0
2104	Хангамж, бараа материалын зардал	118,156.2	156,408.7
2105	Нормативт зардал	151,186.9	268,596.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,201.5	56,031.5
2107	Томиллолт, зочны зардал	13,235.2	11,463.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,377.3	97,064.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	392,284.6	804,757.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	185,108.0	2,196,378.6
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9,396,247.6	760,480.3
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	4,885.1
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	164,985.8	311,725.6
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,231,261.8	453,639.9

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,299,600.7	6,814,502.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	711,411.5	750,574.0
110	Орлогын албан татвар	119,060.9	94,333.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	119,060.9	94,333.5
113	Хөрөнгийн албан татвар	4,960.0	148,565.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	587,390.6	507,674.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,590.9	10,097.0
1181	Газрын төлбөр	10,271.4	6,211.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	571,528.2	491,366.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	167,116.7	255,270.2
120	Нийтлэг татварын бус орлого	167,116.7	255,270.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,421,072.5	5,808,657.8
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,505,220.8	6,058,272.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,505,220.8	6,058,272.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,317,929.8	3,847,653.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,090,429.3	2,200,989.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	262,304.6	291,113.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	429,842.7	581,591.1
2104	Хангамж, бараа материалын зардал	163,970.8	152,905.9
2105	Нормативт зардал	123,420.9	286,076.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,377.6	83,909.2
2107	Томилолт, зочны зардал	13,235.2	11,343.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,917.0	62,837.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,431.7	176,887.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,291.0	2,210,618.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	794,379.9	756,230.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	205,403.7	484,778.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	205,403.7	484,778.4
2200	Дотоод эх үүсвэрээр	205,403.7	484,778.4
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(205,403.7)	(484,778.4)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	588,976.1	271,451.6
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	114,150.3	703,126.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	703,126.4	974,578.1

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,105,890.3	938,260.6	2,045,591.8	-	6,089,742.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	160.2	-	160.2
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	3,105,890.3	938,260.6	2,045,752.0	-	6,089,903.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт					
Зарласан ногдол ашиг					
Тайлант үеийн үр дүн	-	-	9,231,261.8	-	9,231,261.8
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,105,890.3	938,260.6	11,277,013.8	-	15,321,164.8
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,105,890.3	938,260.6	11,277,013.8	-	15,321,164.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	367.1	-	367.1
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	3,105,890.3	938,260.6	11,277,380.9	-	15,321,531.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(367.1)	-	-	(367.1)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт					
Зарласан ногдол ашиг					
Тайлант үеийн үр дүн	-	-	453,639.9	-	453,639.9
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,101,033.7	937,893.5	11,731,020.8	-	15,769,948.1

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,412,538.0	4,064,634.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,837,364.8	3,625,948.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,750,390.6	3,566,605.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,219,554.3	2,149,008.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,924.6	283,143.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	592,682.1	581,591.1
2104	Хангамж, бараа материалын зардал	94,648.5	94,525.2
2105	Нормативт зардал	168,140.6	147,902.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,709.2	112,529.7
2107	Томилолт, зочны зардал	12,869.2	11,093.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,818.7	55,221.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,043.4	131,590.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,974.2	59,343.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,974.2	59,343.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	499,585.5	438,686.4
2200	Дотоод эх үүсвэрээр	499,585.5	438,686.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	75,587.7	-
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,412,538.0	4,326,498.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,376,451.4	2,257,678.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,873,015.9	1,866,710.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,621.9	47,621.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	46,651.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	308,515.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	329,967.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	329,967.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	281,982.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,977.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,968.0
2104	Хангамж, бараа материалын зардал	24,294.9
2105	Нормативт зардал	138,173.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,591.6
2107	Томиллолт, зочны зардал	250.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,775.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,782.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,153.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,320.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,833.7
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	330,335.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	330,335.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	368.6

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Эрдэнэбаатар танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орон нутгийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээ авах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1/79 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

Өмнөдэлгэр сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөгүй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөгүй байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Өмнөдэлгэр сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, төрийн үйлчилгээг ил, тод шуурхай хүртээмжтэй хүргэн ажиллана.” гэж тодорхойлсон байна.

#### **3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **3.4 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 5,101.2 сая төгрөгийн 1 хувь буюу 51.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 38.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 703.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 974.5 сая төгрөг болж, 281.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	701.5	969.3	267.8	99.5
Замд яваа мөнгөн хөрөнгө	1.6	5.2	3.6	0.5
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>703.1</b>	<b>974.5</b>	<b>271.4</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 936.9 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 32.0 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна. Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэлд Эрүүл мэндийн төвийн 7.1 сая төгрөг, тусгай сангуудын 301.4 сая төгрөг, сумын ерөнхий орлогын дансны 628.4 сая төгрөг, арилжааны банкны үлдэгдэлд Шинэс ой ангийн 32.0 сая төгрөг байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 5.2 сая төгрөг байгаа нь оны эцэст орсон үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, бууны албан татвар, малд ногдох албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөртэй холбоотой мөнгөн хөрөнгө байна.

#### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт данс үлдэгдэлгүй байна.

#### 3.5.3 Авлага

Авлагын эхний үлдэгдэл 344.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 440.9 сая төгрөг болж, 96.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага		2.7	2.7
Төлбөртэй үйлчилгээний авлага		216.0	216
Дансны авлага /ТӨҮГ/	0.1		-0.1
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.2	0.6	0.4
Бусад авлага	11.2	18.0	6.8
Зээлийн авлага	332.6	203.6	-129
<b>Дүн</b>	<b>344.1</b>	<b>440.9</b>	<b>96.8</b>

Эх сурвалж: Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажиллагсадтай холбогдсон авлага нь Эрүүл мэндийн төв, Цэцэрлэгийн тайлант онд үүссэн авлага байна.

Төлбөртэй үйлчилгээний авлагын үлдэгдэл Эрүүл мэндийн төвийн даатгалын сангаас дутуу авсан санхүүжилтээс үүсжээ.

Бусад авлага дансны үлдэгдэлд Ерөнхий боловсролын сургуулийн 10.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл, Засаг даргын тамгын газрын 5.8 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн 1.6 сая төгрөгийн өмнөх оны авлагын үлдэгдэл байна.

Зээлийн авлага тайлант онд нэмэгдээгүй, 128.9 сая төгрөгөөр хасагдаж, 203.6 сая төгрөг болсон. Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 139.8 сая төгрөгийн авлага байна.

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 369.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 394.3 сая төгрөг болж, 24.9 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	35.4	65.5	30.1
Бэлэн бүтээгдэхүүн			0.0
Хангамжийн материал	250.6	246.1	-4.5
Мал амьтад	83.4	82.7	-0.7
<b>Дүн</b>	<b>369.4</b>	<b>394.3</b>	<b>24.9</b>

Эх сурвалж: Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материалын 665.0 сая төгрөгийн орлого авснаас 582.3 сая төгрөгийг худалдан авч, 61.7 сая төгрөгийг хандиваар, 21.0 сая төгрөгийг шилжүүлэн авч, нийт 607.0 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 13,960.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 13,926.7 сая төгрөг болж, 34.0 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	13,820.5	13,786.9	(33.6)
Биет бус хөрөнгө	140.2	139.8	(0.4)
<b>Дүн</b>	<b>13,960.7</b>	<b>13,926.7</b>	<b>(34.0)</b>

Эх сурвалж: Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 212.9 сая төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 393.9 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 59.6 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 1.9 сая төгрөг, акталсан 132.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 61.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5.3 сая төгрөг болж, 10.9 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	0.9	2.8	<b>1.90</b>	(3.36)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	12.8		<b>(12.80)</b>	22.65
Байгууллагад төлөх өглөг	47.1	2.5	<b>(44.60)</b>	78.94
Хувь хүмүүст төлөх өглөг	1.0		<b>(1.00)</b>	1.77
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>61.8</b>	<b>5.3</b>	<b>(56.5)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдлийн 5.3 сая төгрөг тайлант онд нэмэгдсэн Эрүүл мэндийн төвийн ажилчидтай холбоотой болон бусад өглөг байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 15,321.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 15,769.9 сая төгрөг болж, 448.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт -/	Дүнд эзлэх хувь
<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>3,105.9</b>	<b>3,101.0</b>	<b>(4.9)</b>	<b>(1.09)</b>
Өмч /төрийн/	3,105.9	3,101.0	<b>(4.9)</b>	(1.09)
Хуримтлагдсан үр дүн	11,277.0	11,731.0	<b>454.0</b>	101.18
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	938.3	937.9	<b>(0.4)</b>	
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			-	
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга			-	
<b>Дүн</b>	<b>15,321.2</b>	<b>15,769.9</b>	<b>448.7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3101.0 сая төгрөг болж 4.9 сая төгрөгөөр буурсан нь Эмийн эргэлтийн сан татан буугдаж, төрийн өмчийг буруулсан байна.

Хуримтлагдсан үр дүн 11,731.0 сая төгрөг болж, 454.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгийн өсөлттэй холбоотой байна.

### 3.5.10 Орлогын данс

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 60.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 19.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 128.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 25.6 сая төгрөгөөр бүрдүүлсэн байна.

**Аудитын илрүүлэлт:** Орлогын данстай холбоотой 39.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

Эрүүл мэндийн төв нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан Эргэлтийн эмийн сангийн 31.9 сая төгрөгийн эмийн хөнгөлөлтийн санхүүжилтийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснийг аудитын явцад үр дүнгийн тайланд залруулсан байна.

Сумын Засаг даргын нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд ахмадын сангийн төвлөрүүлэлтийг нэмж бүртгэснийг залруулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын төрлөөр тулгахад улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын хураамж, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 7.2 сая төгрөгөөр биелээгүй тасарсан зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### 3.5.11 Зардлын данс

Үйл ажиллагаанд нийт 6,915.0 сая төгрөгийн зардал гарснаас цалин шимтгэлд 2,490.8 сая төгрөг буюу 36.0 хувь, тогтмол зардалд 521.8 сая төгрөг буюу 7.5 хувь, нормативт зардалд 268.6 сая төгрөг буюу 3.9 хувь, бараа үйлчилгээний бусад зардалд 804.8 сая төгрөг буюу 11.6 хувь, хөрөнгийн зардалд 268.2 сая төгрөг буюу 3.8 хувийг тус тус зарцуулсан байна.

*Аудитын илрүүлэлт:* Зардлын данстай холбоотой 19.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

*Засаг даргын тамгын газар цалингийн зардлыг үр дүнгийн тайланд 1.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг аудитын явцад үр дүнгийн тайланд залруулсан байна.*

*Ерөнхий боловсролын сургууль бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 3.5 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авч батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчсөн, ажилтнуудад үндэслэлгүй 4.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, бараа материалын орлого, зарлагыг зөрүүлж бүртгэсэн алдааг аудитын явцад залруулсан.*

*Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй, хэмнэвэл зохих урсгал зардлыг 10.3 сая төгрөгөөр хэмнээгүй зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн байна.*

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Өмнөдэлгэр сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай А/22 дугаар тогтоолд зааснаар Өмнөдэлгэр сумын Засаг даргын тайлант онд 154.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 781.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 506.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	25.0	39.8	14.8	159.2
Хөрөнгийн орлого	35.0	51.6	16.6	147.5
Хөрөнгө борлуулсаны орлого	0.0	2.5	2.5	
Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	0.4	0.4	0.0	103.5
Бууны албан татвар	4.9	5.4	0.5	110.1
Малд ногдох албан татвар	0.0	143.2	143.2	
Улсын тэмдэгтийн хураамж	4.0	3.5	-0.5	86.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.5	2.0	1.5	390.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10.0	4.7	-5.3	46.9
Ойн нөөц ашигласны төлбөр	53.2	490.6	437.4	
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2.1	0.8	-1.3	36.9
Газрын төлбөрийн орлого	4.4	6.2	1.8	141.2
Торгуулийн орлого	8.0	7.9	-0.1	99.0
Бусад орлого	7.0	23.4	16.4	333.7
<b>Нийт дүн</b>	<b>154.5</b>	<b>781.9</b>	<b>627.4</b>	<b>506.1</b>

Орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 627.0 сая төгрөгөөр биелсэн харагдаж байгаа боловч орлогын төрлөөр авч үзвэл зарим орлого биелээгүй тасарсан байна. Үүнд:

Орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөж улсын тэмдэгтийн хураамж 0.5 сая төгрөгөөр, торгуулийн орлогыг 0.1 сая төгрөгөөр, цар тахалтай холбоотой төрөөс даасан төлбөр дутуу орж ирснээс хог хаягдлын хураамж 5.3 сая төгрөгөөр, зэрлэг гахайн өвчин гарснаар иргэд тусгай зөвшөөрөл аваагүйгээс ан амьтны нөөц ашигласны төлбөр 1.3 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг тасалсан байна..

Үйл ажиллагааны орлого 14.8 сая төгрөгөөр биелсэн нь 2020 оны ноосны урамшууллын 10%-ийн орлого орсноор, бууны албан татвар 0.5 сая төгрөгөөр биелсэн нь өмнөх оны өр барагдсанаас, ойн нөөц ашигласны төлбөр 437.4 сая төгрөгөөр биелсэн нь хуш модны самар, мод бэлтгэх зөвшөөрөл олгосонтой холбоотой давж биелсэн.

### **Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг 178.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн орлогыг 24.1 сая төгрөгөөр бууруулж 154.5 сая төгрөгөөр баталсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 4,412.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 4,141.9 сая төгрөгийг урсгал зардалд, 195.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 75.6 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,376.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,697.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 47.6 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 175.5 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 115.4 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2,376.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,837.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 47.6 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 175.5 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 154.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос нийт 4,591.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Малын тоо толгойн албан татварын 140.3 сая төгрөгийн орлогыг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн санд 195.0 сая төгрөгөөр 3 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр сумын төвийн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, Баянбулаг гудамжинд гэрэлтүүлэг нэмж суурилуулах, иж бүрэн автомат худаг суурилуулах 3 ажилд санхүүжилтийг бүрэн зарцуулжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 128.9 сая төгрөгөөр бүрдүүлж, батлагдсан төсвөөс 68.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь сум хөгжүүлэх сангийн зээл эргэн төлөгдсөнтэй холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлогыг 25.9 сая төгрөгөөр бүрдүүлж, батлагдсан төсвөөс 6.5 сая төгрөгөөр давж биелүүлсэн нь сумын Засаг даргын тамгын газар 0.6 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг буцааж төлүүлсэн 4.4 сая төгрөгөөр, байгаль хамгаалах сангийн орлогыг 1.5 сая төгрөгөөр төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг биелүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,064.6 сая төгрөг буюу 92.1 хувьтай байгаа нь цалин, шимтгэл, тогтмол зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлыг хэмнэн ажилласантай холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 118.8 сая төгрөгийг улсын төсөвт, 146.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 4.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 240.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 85.4 сая төгрөг нийт 330.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үндсэн цалин, шимтгэлд 60.0 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 24.3 сая төгрөг, нормативт зардалд 138.2 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 16.6 сая төгрөг, томилотод 0.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 1.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 40.8 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 37.3 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 10.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 0.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

*Аудитын илрүүлэлт: Шилэн данстай холбоотой 755.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:*

*Шинэс ойн анги: Шилэн дансны нэгдсэн системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13.8 сая төгрөгийн 1 худалдан авалт, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 0.9 сая төгрөгийн 3 тушаал шийдвэрийг мэдээлээгүй зөрчил илэрснийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн.*

*Иргэдийн төлөөлөгчдийн хурал: Шилэн дансны нэгдсэн системд мэдээлбэл зохих 133.6 сая төгрөгийн 49 мэдээллээс 14.0 сая төгрөгийн 19 мэдээллийг мэдээлж, 119.5 сая төгрөгийн 30 мэдээллийг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.*

*Ерөнхий боловсролын сургууль: Шилэн дансны нэгдсэн системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 65.5 сая төгрөгийн худалдан авалтыг дутуу мэдээлснийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.*

*Эрүүл мэндийн төв: Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш орлогын 25 мөнгөн гүйлгээний 453.5 сая төгрөг, зарлагын 7 мөнгөн гүйлгээний 57.9 сая төгрөг, худалдан авалтын 5 мэдээллийн 44.5 сая төгрөг нийт 555.9 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.*

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 төлбөрийн акт, 16.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 619.4 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 9. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт*  
төгрөг/ /сая

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1.3	1	1.3			100%
Албан шаардлага	4	16.6	4	16.6			100%
Зөвлөмж	5	619.4	5	619.4			100%
<b>Нийт</b>	<b>10</b>	<b>637.3</b>	<b>10</b>	<b>637.3</b>	-	-	

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 тусгайн сангийн нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан.

Аудитад хамрагдсан тус сумын харьяа Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын дунд сургууль, Эрүүл мэндийн төв, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёлын төв, Шинэс сум дундын ой ангийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн. Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд хувийн аудитын “Өндөрхаан итгэл аудит”-ын компани аудит хийж, “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 10.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3.6 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 7.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлээ.

#### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайланг зөрүүтэй нэгтгэсэн байна.

Засаг даргын тамгын газрын нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд 3.6 сая төгрөгийн ахмадын сангийн төвлөрүүлэлтийг илүү нэгтгэн бүртгэж тайлагнасныг залруулсан.

#### Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Акт, албан шаардлага өгөгдөөгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 806.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 33.1 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 773.7 сая төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлээ.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц зүйл байхгүй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Орон нутгийн орлогын биелэлттэй холбоотой асуудал

#### 3.1.1 Илрүүлэлт:

Улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын хураамж, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 7.2 сая төгрөгөөр тасалсан байна.

### 3.1.2 Эрсдэл:

Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлгүй төлөвлөдөг, орлогын төлөвлөгөө биелээгүй байх.

### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж, орлогыг төлөвлөгөөг биелүүлэн ажиллах.

### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b> 2022.04.17	<b>Аудитын нэр:</b> Санхүүгийн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b> ХЭА-2022/08/НА-СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг дарга</b>	<b>Сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13.8 сая төгрөгийн 1 худалдан авалт, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 0.9 сая төгрөгийн 3 тушаал шийдвэрийг тус тус мэдээлээгүй байна.	14.7	Албан шаардлага өгсөн.	Дарга Нягтлан бодогч	Г.Мөнх-Оргил Ц.Бямбасүрэн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн.	Дарга Нягтлан бодогч	Г.Мөнх-Оргил Ц.Бямбасүрэн
3	Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна	-	Зөвлөмж өгсөн.	Дарга Нягтлан бодогч	Г.Мөнх-Оргил Ц.Бямбасүрэн
<b>Шинэс ойн ангийн алдаа, зөрчлийн дүн</b>		<b>14.7</b>			
4	Хэмнэвэл зохих урсгал зардлаас 3.2 сая төгрөг хэмнэхээс 0.1 сая төгрөг хэмнэж, 3.1 сая төгрөг хэмнээгүй байна.	3.1	Албан шаардлага өгсөн.	Дарга Нягтлан бодогч	Т.Бэрцэцэг Ц.Бямбасүрэн
5	Нийт мэдээлбэл зохих 133.6 сая төгрөгийн 49 мэдээллээс 14.0 сая төгрөгийн 19 мэдээллийг мэдээлж, 119.5 сая төгрөгийн 30 мэдээллийг мэдээлээгүй байна. Мэдээллийг 79.5 хувьтай мэдээлсэн байна.	119.5	Албан шаардлага өгсөн.	Дарга Нягтлан бодогч	Т.Бэрцэцэг Ц.Бямбасүрэн
<b>Иргэдийн төлөөлөгчдийн хурлын алдаа, зөрчлийн дүн</b>		<b>122.6</b>			
6	Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу хэмнэвэл зохих урсгал зардлаас 31.3 сая төгрөг хэмнэхээс 24.2 сая төгрөг хэмнэж, 7.2 сая төгрөг хэмнээгүй.	7.2	Албан шаардлага өгсөн.	Дарга Нягтлан бодогч	Л.Баярмаа Б.Гантулга
7	Цалингийн зардлыг үр дүнгийн тайланд 1.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.	1.1	Залруулга хийсэн.	Нягтлан бодогч	Б.Гантулга
<b>Засаг даргын тамгын газрын алдаа, зөрчлийн дүн</b>		<b>8.3</b>			
8	БҮТЭЗ-ээс хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авсан.	3.5	Албан шаардлага өгсөн.	Захирал Нягтлан бодогч	Э.Энхбаатар М.Алтантуяа

9	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг дутуу мэдээлсэн.	65.5	Албан шаардлага өгсөн.	Захирал Нягтлан бодогч	Э.Энхбаатар М.Алтантуяа
10	Үндэслэлгүй тэтгэмж олгосон	4.2	Албан шаардлага өгсөн.	Захирал Нягтлан бодогч	Э.Энхбаатар М.Алтантуяа
11	Бараа материалын орлого, зарлагын данс зөрүүлж бүртгэсэн.	0.1	Залруулга хийсэн.	Захирал Нягтлан бодогч	Э.Энхбаатар М.Алтантуяа
<b>Ерөнхий боловсролын сургуулийн алдаа, зөрчлийн дүн</b>		<b>73.4</b>			
12	Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш орлогын 25 мөнгөн гүйлгээ 453.5 сая төгрөг, зарлагын 7 мөнгөн гүйлгээ 57.9 сая төгрөг, худалдан авалтын 5 мэдээлэл 44.5 сая төгрөг, нийт 555.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ.	555.9	Албан шаардлага өгсөн.	Эрхлэгч Нягтлан бодогч	Ц.Ариунтунгалаг Ц.Болорцэцэг
13	Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжаад гарсан Эргэлтийн эмийн сангийн эмийн хөнгөлөлтийн санхүүжилтийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн.	31.9	Залруулга хийсэн.	Нягтлан бодогч	Ц.Болорцэцэг
<b>Эрүүл мэндийн төвийн алдаа, зөрчлийн дүн</b>		<b>587.8</b>			
14	Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд ахмадын сангийн төвлөрүүлэлтийг нэгтгэсэн.	3.6	Залруулга хийсэн.	Нягтлан бодогч	Б.Гантулга
15	Улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын хураамж, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг биелүүлээгүй.	7.2	Зөвлөмж өгсөн.	Засаг дарга Нягтлан бодогч	Б.Эрдэнэбаатар Б.Гантулга
<b>Засаг даргын алдаа, зөрчлийн дүн</b>		<b>10.8</b>			
<b>Нийт алдаа, зөрчлийн дүн</b>		<b>817.6</b>			